



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/173/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Баярмаа
Утас: 261628 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн
Захирал: О.Бурмаа
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
Аудитор: Д.Даваасүрэн
Утас: 99092231 Цахим хаяг: aetb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага	23
5.3 Зөвлөмж	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ОЙН ГАЗРЫН ДАРГА Б.ОЮУНСАНАА
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/356

танай _____-ны № _____-г

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Хандиваар хүлээн авсан бараа материалын дансанд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинж чанартай 39 ширхэг 52,890.0 мянган төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүй шууд зарлагдсан;
- Бараа материалын данснаас 16,470.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагдсан;
- Авлагын дансанд бүртгэлтэй 141,151.6 мянган төгрөгийн авлага, 155,802.3 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Ойн газраас Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны алба хаагчид болон гэрээт ажиллагсдын томилолтын зардалд 37,270.0 мянган төгрөг, томилолтын тушаалгүй 1,360.0 мянган төгрөгийг олгосон;
- Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын болон Ойн газрын даргын тушаалуудаар гадаад томилолтоор ажилласан алба хаагчдын томилолтын 12,962.1 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу;

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-50.Docx

1526140742

- Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хашаа, хамгаалалт байгуулахад 7,121,400.0 мянган төгрөг, усалгааны систем худаг байгуулахад 4,998,698.9 мянган төгрөг, төрийн далбаа мандуулах төмөр шон тээвэрлэн суурилуулах ажилд 10,000.0 мянган төгрөг, нийт 12,130,098.9 мянган төгрөгийг зарцуулсан;
- Ойжуулалт хөтөлбөрийн төсвөөс газрын даргын тушаалаар хөлсөөр ажиллуулах гэрээг 21 иргэнтэй байгуулж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд нийт 287,174.3 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, гэсэн заалтуудтай нийцээгүй, Санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ойжуулалтын хөтөлбөрийн 45,990,834.1 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 29,634,374.8 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дутуу олгосноос 5 иргэн, 111 аж ахуйн нэгж байгууллагад төлөх 16,000,741.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй нөхцлөөр 2,307,856.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Ойн газрын даргын 2025 оны А/312 дугаар тушаалаар 4 иргэн, 2 нөхөрлөл, төрийн болон хувийн 26 аж ахуйн нэгж байгууллагад олгохоор баталсан байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,880,518,445.46	19,114,446,009.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,934,008.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,934,008.00	-
31210	Төгрөг	20,934,008.00	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,934,008.00	-
33	АВЛАГА	324,893,202.06	182,056,679.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	643,491.72
33300	Татаас, санхүүжилтийн авлага	324,893,202.06	140,508,087.74
33500	Бусад авлага	324,893,202.06	40,905,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,534,691,235.40	18,932,389,329.78
35100	Түүхий эд материал	3,736,237,209.40	5,787,830,572.40
35110	Тусгай зориулалттай материал	3,736,237,209.40	5,787,830,572.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	12,120,098,921.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	448,200,586.00
35400	Хангамжийн материал	798,454,026.00	576,259,250.38
35410	Бичиг хэргийн материал	3,628,000.00	3,625,725.00
35420	Аж ахуйн материал	243,968,680.00	29,218,774.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,020,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,071,611.00	3,487,096.38
35470	Бусад хангамжийн материал	547,785,735.00	538,907,655.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,261,503,390.76	14,419,153,749.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,261,503,390.76	14,419,153,749.56
39200	Биет хөрөнгө	8,058,242,994.56	8,145,773,427.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,352,099,953.24	4,798,840,054.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(366,074,614.23)	(694,693,833.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,480,052,935.50	1,121,367,496.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,694,784,188.32)	(171,303,332.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,659,852,908.90	1,743,670,634.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(642,026,642.79)	(767,013,588.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,566,916.13	123,234,976.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,519,668.97)	(14,738,898.99)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,887,380,953.26	1,887,380,953.26
39210	Хуримтлагдсан элэгдэл	(29,214,249.78)	(204,499,748.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	646,542,800.00	636,695,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(274,634,108.38)	(313,167,086.13)
39300	Биет бус хөрөнгө	6,203,260,396.20	6,273,380,322.42
39301	Програм хангамж	73,664,895.33	193,064,895.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	(30,010,499.16)	(79,290,572.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,168,601,000.00	6,159,606,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(8,994,999.97)	-
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,142,021,836.22	33,533,599,758.80
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,934,008.00	16,000,741,559.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,934,008.00	16,000,741,559.12
41300	Өглөг	20,934,008.00	16,000,741,559.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41360	Бусад өглөг	20,934,008.00	16,000,741,559.12

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	20,934,008.00	16,000,741,559.12
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
422	Урт хугацаат зээл	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,121,087,828.22	17,532,858,199.68
51	Засгийн газрын хувь оролцоо	19,121,087,828.22	17,532,858,199.68
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,696,476,268.14	6,696,476,268.14
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,696,476,268.14	6,696,476,268.14
51200	Хуримтлагдсан үр дүн	12,349,784,306.89	10,761,554,678.35
51210	Өмнөх үеийн үр дүн	4,072,342,243.44	12,463,214,306.89
51220	Тайлант үеийн үр дүн	8,277,442,063.45	(1,701,659,628.54)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,827,253.19	74,827,253.19
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,142,021,836.22	33,533,599,758.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,880,518,445.46	19,114,446,009.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,934,008.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,934,008.00	-
31210	Төгрөг	20,934,008.00	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,934,008.00	-
33	АВЛАГА	324,893,202.06	182,056,679.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	643,491.72
33300	Татаас, санхүүжилтийн авлага	324,893,202.06	140,508,087.74
33500	Бусад авлага	324,893,202.06	40,905,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,534,691,235.40	18,932,389,329.78
35100	Түүхий эд материал	3,736,237,209.40	5,787,830,572.40
35110	Тусгай зориулалттай материал	3,736,237,209.40	5,787,830,572.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	12,120,098,921.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	448,200,586.00
35400	Хангамжийн материал	798,454,026.00	576,259,250.38
35410	Бичиг хэргийн материал	3,628,000.00	3,625,725.00
35420	Аж ахуйн материал	243,968,680.00	29,218,774.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,020,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,071,611.00	3,487,096.38
35470	Бусад хангамжийн материал	547,785,735.00	538,907,655.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,261,503,390.76	14,419,153,749.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,261,503,390.76	14,419,153,749.56
39200	Биет хөрөнгө	8,058,242,994.56	8,145,773,427.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,352,099,953.24	4,798,840,054.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(366,074,614.23)	(694,693,833.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,480,052,935.50	1,121,367,496.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,694,784,188.32)	(171,303,332.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,659,852,908.90	1,743,670,634.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(642,026,642.79)	(767,013,588.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,566,916.13	123,234,976.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,519,668.97)	(14,738,898.99)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,887,380,953.26	1,887,380,953.26
39210	Хуримтлагдсан элэгдэл	(29,214,249.78)	(204,499,748.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	646,542,800.00	636,695,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(274,634,108.38)	(313,167,086.13)
39300	Биет бус хөрөнгө	6,203,260,396.20	6,273,380,322.42
39301	Програм хангамж	73,664,895.33	193,064,895.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	(30,010,499.16)	(79,290,572.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,168,601,000.00	6,159,606,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(8,994,999.97)	-
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,142,021,836.22	33,533,599,758.80
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,934,008.00	16,000,741,559.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,934,008.00	16,000,741,559.12
41300	Өглөг	20,934,008.00	16,000,741,559.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41360	Бусад өглөг	20,934,008.00	16,000,741,559.12

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	20,934,008.00	16,000,741,559.12
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
422	Урт хугацаат зээл	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,121,087,828.22	17,532,858,199.68
51	Засгийн газрын хувь оролцоо	19,121,087,828.22	17,532,858,199.68
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,696,476,268.14	6,696,476,268.14
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,696,476,268.14	6,696,476,268.14
51200	Хуримтлагдсан үр дүн	12,349,784,306.89	10,761,554,678.35
51210	Өмнөх үеийн үр дүн	4,072,342,243.44	12,463,214,306.89
51220	Тайлант үеийн үр дүн	8,277,442,063.45	(1,701,659,628.54)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,827,253.19	74,827,253.19
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,142,021,836.22	33,533,599,758.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-ын хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,914,997,243.44	10,686,300,764.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	157,345,000.00	157,345,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	4,072,342,243.44	10,843,645,764.77
9	Тайлант үеийн үр дүн	-	-	8,277,442,063.45	8,277,442,063.45
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	12,349,784,306.89	19,121,087,828.22
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	12,349,784,306.89	19,121,087,828.22
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	113,430,000.00	113,430,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	12,463,214,306.89	19,234,517,828.22
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,701,659,628.54)	(1,701,659,628.54)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	10,761,554,678.35	17,532,858,199.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	49,661,008,803.85	30,597,398,163.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,634,116.00	59,605,114.00
120	Нийтлэг татварын бус орлого	152,634,116.00	59,605,114.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	21,242,853.00	59,605,114.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	21,242,853.00	59,605,114.00
120009	Бусад орлого	131,391,263.00	-
122	Тусламжийн орлого	-	30,537,793,049.27
1221	Хандив тусламж /дотоод	-	30,537,793,049.27
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	29,980,008,223.06
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	29,655,115,021.00
122114	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийн буцаалтын орлого	-	324,893,202.06
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	557,784,826.21
12213	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	498,062,420.55
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	59,722,405.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,508,374,687.85	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	46,364,500,755.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	46,364,500,755.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,143,873,932.85	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,089,792,133.85	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,081,799.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,031,990,750.85	30,604,032,171.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,031,990,750.85	30,604,032,171.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,160,592,185.22	30,189,546,849.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,641,364,656.89	1,989,625,533.74
210101	Үндсэн цалин	999,004,944.82	1,016,831,357.63
210102	Нэмэгдэл	197,706,209.11	343,600,619.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	188,157,186.40	268,277,506.12
210104	Урамшуулал	114,889,366.05	111,140,800.25
210105	Гэрээт ажлын хөлс	141,606,950.51	249,775,250.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,609,092.03	245,560,005.87
210201	Тэтгэврийн даатгал	156,450,586.59	175,759,805.87
210202	Тэтгэмжийн даатгал	14,888,124.07	17,468,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,605,502.45	8,731,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,209,615.71	8,720,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,455,263.21	34,880,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,530,075.45	120,787,458.33

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	6,330,075.45	20,046,461.55
210304	Байрны түрээс	61,200,000.00	100,740,996.78
2104	Хангамж, бараа материалын зардал	201,835,372.95	92,725,100.16
210401	Бичиг хэрэг	16,512,295.00	7,739,217.00
210402	Тээвэр, шатахуун	155,635,418.00	55,363,264.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	13,787,242.95	11,244,780.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,200,417.00	18,107,839.00
2105	Нормативт зардал	14,561,390.00	7,650,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,561,390.00	7,650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,448,780.00	55,253,625.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,686,600.00	35,302,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,132,950.00	-
210604	Урсгал засвар	79,629,230.00	19,951,225.91
2107	Томилолт, зочны зардал	337,793,440.00	92,937,430.00
210701	Гадаад албан томилолт	31,755,440.00	21,717,430.00
210702	Дотоод албан томилолт	306,038,000.00	71,220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,529,820,017.90	27,582,028,045.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,503,712,485.80	27,520,057,235.05
210803	Даатгалын үйлчилгээ	11,219,667.10	23,515,606.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,619,965.00	8,234,012.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,842,600.00	4,008,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,425,300.00	24,092,700.00
210807	Газрын төлбөр	-	2,119,992.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,629,360.00	2,979,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,798,460.00	629,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,830,900.00	2,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	871,398,565.63	414,485,322.21
2131	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	280,575,822.21
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	280,575,822.21
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	39,440,228.81
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	59,722,405.66
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,905,100.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	140,508,087.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,351,000.00	133,909,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,351,000.00	25,039,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	108,870,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	823,047,565.63	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	494,409,364.57	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	328,638,201.06	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,629,018,053.00	(6,634,008.00)

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,497,626,790.00	14,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,497,626,790.00	14,300,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,617,694,690.00	14,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	879,932,100.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,497,626,790.00)	(14,300,000.00)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	110,457,255.00	-
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	110,457,255.00	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	110,457,255.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	241,848,518.00	(20,934,008.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,934,008.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,934,008.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	45,990,834,100.00	29,675,279,906.19	16,315,554,193.81	64.52
Татварын бус орлого	45,990,834,100.00	29,675,279,906.19	16,315,554,193.81	64.52
Бараа, үйлчилгээний орлого	18,700,000.00	59,605,114.00	(40,905,114.00)	318.74
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	18,700,000.00	59,605,114.00	(40,905,114.00)	318.74
Тусламжийн орлого	45,972,134,100.00	29,615,674,792.19	16,356,459,307.81	64.42
Төсвөөс санхүүжих	45,972,134,100.00	29,615,674,792.19	16,356,459,307.81	64.42
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,990,834,100.00	29,655,308,814.19	16,335,256,285.81	64.48
УРСГАЛ ЗАРДАЛ	45,990,834,100.00	29,655,308,814.19	16,335,256,285.81	64.48
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,854,499,600.00	29,521,399,314.19	16,332,831,285.81	64.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,799,733,600.00	1,752,339,063.74	47,394,536.26	97.37
Үндсэн цалин	800,512,800.00	779,544,887.63	20,967,912.37	97.38
Нэмэгдэл	373,834,200.00	343,600,619.13	30,233,580.87	91.91
Унаа хоолны хөнгөлөлт	220,694,900.00	268,277,506.12	(47,582,606.12)	121.56
Урамшуулал	127,128,000.00	111,140,800.25	15,987,199.75	87.42
Гэрээт ажлын хөлс	277,563,700.00	249,775,250.61	27,788,449.39	89.99
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,248,100.00	218,272,061.82	4,976,038.18	97.77
Тэтгэврийн даатгал	151,857,900.00	148,471,861.82	3,386,038.18	97.77
Тэтгэмжийн даатгал	17,865,500.00	17,468,100.00	397,400.00	97.78
ҮОМШӨ-ний даатгал	8,930,300.00	8,731,500.00	198,800.00	97.77
Ажилгүйдлийн даатгал	8,918,800.00	8,720,000.00	198,800.00	97.77
Эрүүл мэндийн даатгал	35,675,600.00	34,880,600.00	795,000.00	97.77
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,757,300.00	103,147,458.33	6,609,841.67	93.98
Гэрэл, цахилгаан	20,465,800.00	20,046,461.55	419,338.45	97.95
Түлш, халаалт	6,100,100.00	-	6,100,100.00	-
Байрны түрээс	83,191,400.00	83,100,996.78	90,403.22	99.89
Хангамж, бараа материалын зардал	96,227,800.00	72,913,680.16	23,314,119.84	75.77
Бичиг хэрэг	11,777,600.00	7,739,217.00	4,038,383.00	65.71
Тээвэр, шатахуун	42,677,200.00	37,701,844.00	4,975,356.00	88.34
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,062,900.00	11,244,780.16	11,818,119.84	48.76
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,796,400.00	270,000.00	2,526,400.00	9.66
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,913,700.00	15,957,839.00	(44,139.00)	100.28
Нормативт зардал	11,558,400.00	7,650,000.00	3,908,400.00	66.19
Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,558,400.00	7,650,000.00	3,908,400.00	66.19
Эд хогшил, урсгал засварын зардал	97,913,000.00	55,253,625.91	42,659,374.09	56.43
Багаж, техник, хэрэгсэл	75,282,800.00	35,302,400.00	39,980,400.00	46.89
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,705,600.00	-	1,705,600.00	-

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Урсгал засвар	20,924,600.00	19,951,225.91	973,374.09	95.35
Томилолт, зочны зардал	38,699,000.00	38,430,000.00	269,000.00	99.30
Дотоод албан томилолт	38,699,000.00	38,430,000.00	269,000.00	99.30
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,473,016,000.00	27,270,413,774.23	16,202,602,225.77	62.73
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,388,806,900.00	27,210,132,964.23	16,178,673,935.77	62.71
Даатгалын үйлчилгээ	24,960,400.00	21,825,606.00	3,134,794.00	87.44
Тээврийн хэрэгслийн татвар	15,490,500.00	8,234,012.00	7,256,488.00	53.16
Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,008,500.00	4,008,500.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,506,300.00	24,092,700.00	4,413,600.00	84.52
Газрын төлбөр	4,461,500.00	2,119,992.00	2,341,508.00	47.52
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,781,900.00	-	6,781,900.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	4,346,400.00	2,979,650.00	1,366,750.00	68.55
Бараа үйлчилгээний бусад зардал	629,700.00	629,650.00	50.00	99.99
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,716,700.00	2,350,000.00	1,366,700.00	63.23
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,334,500.00	133,909,500.00	2,425,000.00	98.22
Бусад урсгал шилжүүлэг	136,334,500.00	133,909,500.00	2,425,000.00	98.22
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,464,000.00	25,039,000.00	2,425,000.00	91.17
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,870,500.00	108,870,500.00	-	100.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	19,971,092.00	(19,971,092.00)	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	19,971,092.00	(19,971,092.00)	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	20,934,008.00	(20,934,008.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,934,008.00	(20,934,008.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	65.00	(30.00)	185.71
Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	30.00	60.00	(30.00)	200.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.00	65.00	(30.00)	185.71
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	26.00	26.00	-	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	-	100.00
Гэрээт ажилтан	-	30.00	(30.00)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл <i>/төгрөгөөр/</i>
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	882,678,028.27
Татварын бус орлого	-	882,678,028.27
Бараа, үйлчилгээний орлого	-	59,722,405.66
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	59,722,405.66
Тусламжийн орлого	-	822,955,622.61
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	498,062,420.55
Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийн буцаалтын орлого	-	324,893,202.06
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	882,678,028.27
УРСГАЛ ЗАРДАЛ	-	868,378,028.27
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	668,147,534.87
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	237,286,470.00
Үндсэн цалин	-	237,286,470.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	27,287,944.05
Нийгмийн даатгалын шимтгэл	-	27,287,944.05
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	17,640,000.00
Байрны түрээс	-	17,640,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	19,811,420.00
Тээвэр, шатахуун	-	17,661,420.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	-	2,150,000.00
Томилолт, зочны зардал	-	54,507,430.00
Гадаад албан томилолт	-	21,717,430.00
Дотоод албан томилолт	-	32,790,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	-	311,614,270.82
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	309,924,270.82
Даатгалын үйлчилгээ	-	1,690,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,230,493.40
Бусад урсгал шилжүүлэг	-	200,230,493.40
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	200,230,493.40
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	14,300,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	14,300,000.00
Тоног төхөөрөмж	-	14,300,000.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ойн газар нь Байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилгод нийцүүлэн ойн эко-системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, ойн тогтвортой менежментийг бий болгох талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон удирдлагын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Ойн газар нь тайлант онд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд ойн талаарх чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар сайдыг мэргэжлийн өндөр түвшний, цаг үеэ олсон шуурхай мэдээллээр хангах, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлсон байна.

1. Байгалийн унаган төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна;
2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэнэ. Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг явуулж, ойн нөөц, түүний өөрчлөлтийг тооцно;
3. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомсдол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ;
4. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ;
5. Цөлжилт газрын доройтлыг бууруулна;
6. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, ойн сайн засаглалыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн Газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Сангийн сайдын 2025 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Тайлант онд Ойн газарт Архивын ерөнхий газраас улсын үзлэг явуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ойн газрын даргын 2024 оны А/313 дугаар тушаалаар баталсан “Ойн газарт мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Энэ нь он дамжин хэрэгжсэн www.Forest.gov.mn цахим хуудсын хөгжүүлэлтийн зардлын 13,930.0 мянган төгрөг, ойн нөөцийн дагалт баялаг ашиглах /epf.forest.gov.mn/ программын 99,500.0 мянган төгрөгийн, нийт 113,430.0 мянган төгрөгийн программ хангамжийг 2025 онд хүлээн авч өмнөх үеийн үр дүн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,391,577.9 мянган төгрөгөөр буюу 75.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,934.0	-	(20,934.0)
Авлага	324,893.2	182,056.7	(142,836.5)
Бараа материал	4,534,691.2	18,932,389.3	14,397,698.1
Үндсэн хөрөнгө	14,261,503.4	14,419,153.8	157,650.4
Нийт хөрөнгө	19,142,021.8	33,533,599.8	14,391,578.0
Өр төлбөр	20,934.0	16,000,741.6	15,979,807.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,121,087.8	17,532,858.2	(1,588,229.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	19,142,021.8	33,533,599.8	14,391,578.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь 20,934.0 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг буцаан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 142,836.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд он дамжин хэрэгжиж байгаа Афоко төслийн 324,893.2 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг зарцуулж, Афоко төслийн үлдэгдэл 140,508.10 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар, давсан орлогын 40,905.10 мянган төгрөгийг авлагаар, НДШ, ХАОАТ-ын авлага 643.50 мянган төгрөгийг тус тус бүртгэсэн нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,932,389.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,397,698.1 мянган төгрөгөөр өсөхөд дараах өөрчлөлтүүд нөлөөлсөн байна.

- Шинэ Хархорум хотын ногоон бүсэд байгуулсан хашаа, хамгаалалтын 7,121,400.0 мянган төгрөг, усалгааны систем худгийн 4,998,698.9 мянган төгрөг, нийт 12,120,098.9 мянган төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн;
- Оюу толгой компаниас тарьц суулгацын үнэнд дүйцүүлэн өгсөн машин тоног төхөөрөмжийн 2,420,855.0 мянган төгрөг, “Эрүүл ой” төслийн хүрээнд Рио Тинто Монголиа ХХК-ийн хандивын 45 ширхэг Blackview 9300 маркийн гар утасны 40,815.0 мянган төгрөг, нийт 2,461,700.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын материал дансанд бүртгэсэн;
- Бараа материалын бусад дансанд 4,350,620.4 мянган төгрөгийг бүртгэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,419,153.8 мянган төгрөг болж 157,650.4 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Төсвийн хөрөнгөөр 348,912.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- БОУАӨЯ-ны тендерээр тайлант онд хийгдсэн 383,932.5 мянган төгрөгийн өртөг бүхий авто гараашийг үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлогоор бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 812 дугаар тогтоолоор 39 ширхэг 1,488,189.8 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн үнийг 446,120.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлогоор бүртгэсэнээр нэмэгдсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 826 дугаар тогтоолоор 232,980.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 858 дугаар тогтоолоор 143,119.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 16,000,741.6 мянган төгрөг болж 15,979,807.6 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвөөс 16,317,019.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас шалтгаалан 119 байгууллага, 5 иргэнд нийт 16,000,741.6 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Өмнөх үеийн үр дүнг 113,430.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь он дамжин хэрэгжсэн www.Forest.gov.mn цахим хуудсын хөгжүүлэлтийн зардлын 13,930.0 мянган төгрөгийн, ойн нөөцийн дагалт баялаг ашиглах erp.forest.gov.mn/ программын 99,500.0 мянган төгрөгийг тус тус өмнөх үеийн үр дүн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 1,588,229.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус газрын биет бус хөрөнгийн дансанд 6,361,225.9 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн, газар зүйн мэдээллийн системийн, газар эзэмших эрх, forest.gov.mn, terbummod.mn, erp.forest.gov.mn Ойн нөөцийн дагалт баялаг ашиглах зэрэг 11 программ хангамж бүртгэлтэй. Тайлант онд программ хангамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр, лицензийн төлбөрт 83,823.0 мянган төгрөг төлсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 85,624,582.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 85,624,582.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 23,629,582.9 мянган төгрөгөөр бууруулж 61,995,000.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн төслийн саналыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 22,716,027.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 440,717.2 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 195,727.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 161,330.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 104,996.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 90,481.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 34,851.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 16,004,165.9 мянган төгрөгөөр бууруулж 45,990,834.1 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ойжуулалт” хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтэд улсын төсвөөс 45,972,134.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 18,700.0 мянган төгрөг, нийт 45,990,834.1 мянган төгрөгийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр “Ойжуулалт” хөтөлбөрийн санхүүжилтэд улсын төсвөөс 29,615,674.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 59,605.1 мянган төгрөг, нийт 29,675,279.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 29,521,399.3 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 133,909.5 мянган төгрөг, нийт 29,655,308.8 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 18,700.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 29,655,308.8 мянган төгрөг буюу 64.5 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс 16,355,525.3 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71403	Ойжуулалт	45,990,834.1	29,655,308.8	16,335,525.3	64.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,059,130.5	1,990,221.4	68,909.1	96.7
80219	Харуул хамгаалалтын зардал	43,057.8	18,230.6	24,827.2	42.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	136,334.5	133,909.5	2,425.0	98.2
81708	Ойжуулалт	43,752,311.3	27,512,947.3	16,239,364.0	62.9

Засгийн газрын 2022 оны 272 дугаар тогтоолоор Ойн газрын орон тооны дээд хязгаарыг 38 байхаар баталсан. Засгийн газрын 9 хувийн цомхотголоор 35 болгож, гэрээт 3 алба хаагчийг цомхотголд хамруулсан байна. Тайлант онд тус газар нь батлагдсан орон тооны хязгаараас илүү 21 иргэнтэй “Хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулан Ойжуулалт хөтөлбөрийн төсвөөс цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлд нийт 287,174.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ойн газрын даргын 2024 оны А/348 тушаалаар албан хаагчийн өдрийн хоолны зардлыг 34.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна. Тайлант онд ажилчдын хоол, унааны хөнгөлөлтөд 220,694.9 мянган төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 268,277.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд тус газар гадаад томилолтын 4 арга хэмжээнд 5 хүнийг хамруулж, нийт 31,784.0 мянган төгрөг, сургалтад 189,905.0 мянган төгрөг, хурал зөвлөгөөний арга хэмжээнд 416,396.0 мянган төгрөг, тус тус зарцуулсан байна.

Ой ба хүнс өдөрлөг, Надад хамаатай нөлөөллийн аян, Хашаандаа 5 мод тарья аян, байгаль орчны чиглэлээр эрэн сурвалжлах нэвтрүүлэг, тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг олон нийтэд сурталчилах зэрэг контент сурталчилгааны зардалд нийт 314,082.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд АFoCo/035/2022 төслийн 184,228.2 мянган төгрөг, АFoCo/039/2023 төслийн 313,834.2 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн 324,893.2 мянган төгрөг, үйл ажиллагааны нэмэлт орлогын 59,722.4 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос бараа, ажил, үйлчилгээний зардалд 668,147.5 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 200,230.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 14,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 140,508.1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ойн газар болон Азийн хамтын ажиллагааны байгууллага /АFoCo/ хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2 төсөл хэрэгжүүлж, нийт 498,062.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төслийн хэрэгжилтийн талаар:

1. АFoCo/039/2023 төсөл: “Монгол улсад Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор өндөр хүчин чадалтай мод үржүүлгийн газар байгуулах, чадавхыг бэхжүүлэх замаар ойг нөхөн сэргээх” төсөл 2024-2025 онд хэрэгжсэн.
 - Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн Өлзийт, Түргэний голын эрэг дагуу 20 га, Эрээний нуруунд 100 га, Дорнод аймгийн Баян-уул суманд 70 га талбай бүхий мод үржүүлгийн газар байгуулж ойн нөхөн сэргээлт, ойжуулалтад нийт 310,000.0 мянган ширхэг суулгац тариалсан;

- Суулгац үйлдвэрлэх, мод тарих, ой цэвэрлэх, хамгаалах, гал түймрийн, хортон шавьжийн талаарх нийт 12 удаагийн сургалтуудыг зохион байгуулж, 4 оюутанд судалгааны тэтгэлэг олгосон;
 - Төслийн үйл ажиллагааг сурталчлах 20 контент бэлтгэсэн;
 - Нийт 9 төрлийн 50.5 кг үрийг бэлтгэж шинээр байгуулагдсан мод үржүүлгийн газарт хүлээлгэн өгсөн.
2. AFoCo/035/2022 төсөл: “Ойн дагалт баялгаас гарах бүтээгдэхүүнээс олох орлогыг нэмэгдүүлэх замаар орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах” бүс нутгийн төсөл 2023-2026 онд дуусна.
- Тус төсөл Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд 1426 га талбай бүхий ойн санг гэрээгээр эзэмшдэг;
 - Судалгаа, ойн дагалт баялгийн үйлдвэрлэлийн нөөцийн үнэлгээ, зах зээлийн судалгааг хийсэн;
 - Цайны ургамлуудыг тариалж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх 7 удаагийн сургалтууд, судалгааны аяллыг БНСУ болон Дархан, Сэлэнгэ аймгуудад тус тус зохион байгуулсан;
 - Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хус модыг ашиглан мөөгний үйлдвэрлэл хийх ариутгагч, автоклав, хуурах тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	AFoCo/039/2023	2024-2025	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор өндөр хүчин чадалтай мод үржүүлгийн газар байгуулах, чадавхыг бэхжүүлэх замаар ойг нөхөн сэргээх	Хэрэгжиж дууссан	313,834.2	313,834.2
2	AFoCo/035/2022	2023-2026	Ойн дагалт баялаг ашигладаг ААН-ийн чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах	2026 оны 11 сард дуусна	184,228.2	184,228.2
Дүн					498,062.4	498,062.4

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Ойн газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар 67 бараа, ажил, үйлчилгээний 58,609,244.6 мянган төгрөгөөр баталсныг, 2025 оны А/124 дугаар тушаалаар 55 бараа, ажил, үйлчилгээний 57,333,773.0 мянган төгрөг болгон бууруулж худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна.

Гүйцэтгэлээр 41,158,930.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 407,571.5 мянган төгрөгийн бараа, 979,550.5 мянган төгрөгийн үйлчилгээ, 38,973,804.7 мянган төгрөгийн ажил, нийт 40,380,426.7 мянган төгрөгийн 111 гэрээг байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ойн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн газрын үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгө бараа материалыг тушаал шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсэхгүй байх, үүссэн авлага өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хийх, татварын цахим төлбөрийн системд и-баримтыг бүртгэж хэвших зөвлөмжүүдийг өглөө.

Аудитыг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн, аудиторын туслах Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэж, ахлах аудитор О.Чулуунбаатар, захирал О.Бурмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллав.

Ойн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-д 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 01/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 19,142,021.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 191,420.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 33,533,599.8 мянган төгрөгөөс 335,336.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 37,894.8 мянган төгрөгийн зөрчил илэрсний таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт: Ойн газрын даргын 2025 оны А/83, А/92 тушаалаар жүжиг, дуу, контент бүтээхэд 31,840.0 мянган төгрөг, цай кофены зардалд 6,054.8 мянган төгрөг, нийт 37,894.8 мянган төгрөгийн төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж,

Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;" 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 37,894.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 576.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 3 төрлийн мэдээллийг /санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө/ хугацаанд нь байршуулаагүй, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор"; 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.6-т "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр." гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд дараах зөрчил илэрлээ.

Илрүүлэлт: Ойн газрын даргын 2025 оны Б/08 тушаалаар төрийн жинхэнэ албанаас түр чөлөөлөгдсөн алба хаагчийн суралцах хугацаан дахь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 576.8 мянган төгрөгийг төлсөн нь Засгийн газрын хүчингүй болсон

1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх" журмыг үндэслэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Монгол улсын Засгийн газрын 2023 оны 416 дугаар тогтоолын 1-т 1."Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай." гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэр гаргахдаа хүчинтэй хууль, журмын холбогдох заалтыг үндэслэл болгож байх зөвлөмж өгөв.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ойн газрын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг завсрын аудитад хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 957,625.8 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 2 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 91.4 хувийн биелэлттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	205,710.3	1.0	205,710.2	100.0
Албан шаардлага	8	668,393.6	6.0	586,506.8	87.7
Зөвлөмж	4	83,521.9	4.0	83,521.9	100.0
Нийт дүн	14	957,625.8	11.0	875,738.9	91.4

Тооллогоор биетээр байхгүй 81,886.9 мянган төгрөгийн автомашин, компьютер болон бусад хөрөнгийг шийдвэрлэх албан шаардлага хэрэгжилтийн шатанд байна.

Мөн байгууллагын тусгай хэрэгцээнд ашиглах газрыг зориулалтын дагуу ашиглах, маргаантай газрын асуудлыг хуулийн байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх албан шаардлага хэрэгжилтийн шатанд, тусгай хэрэгцээнд ашиглах газраас 14 иргэн газрын маргаантай байснаас 7 иргэний газрыг шүүхийн шийдвэрээр чөлөөлж, 7 газрыг бүрэн чөлөөлөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзсэн.

- Ойн газарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн гэрээний хугацаа 2026 онд дуусах тул санхүүжилт, түүний хэрэгжилтийг бүрэн үнэлсэн эсэхийг шалгах;
- Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй нөхцлөөр олгохоор шийдвэрлэсэн тоног төхөөрөмжийн хэрэгжилтийн талаар хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 276,004.5 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдан авсан орлогыг 270,502.5 мянган төгрөгөөр илүү, акталсан хөрөнгийн дүнг 5,329.0 мянган төгрөгөөр дутуу, хөрөнгийн ашиглалтын хугацаа, шинэчлэн тогтоосон үнийн дүнг 173.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө “арилжааны/солилцооны бус ажил гүйлгээг бодит үнэ цэнээр хэмжинэ.” гэж заасантай нийцэхгүй², санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12,848,369.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1,776.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 417,906.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага, 12,428,687.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,848,369.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12,513,033.8 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Томилолтоор ажилласан 62 албан хаагчдад хоол унааны хөнгөлөлтийн 1,776.0 мянган төгрөгийг илүү, 999.0 мянган төгрөгийг дутуу тус тус тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон хоол, унааны хөнгөлөлтийн мөнгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх

5.2 Албан шаардлага

1. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Хандиваар хүлээн авсан бараа материалын дансанд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинж чанартай 39 ширхэг 52,890.0 мянган төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүй шууд зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлээс хассан зөрчлийг таслан зогсоох.

2. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Ойн газрын даргын 2025 оны А/232 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн 17947 ширхэг 144,599.6 төгрөгийн үнэ бүхий бараа материалыг зарлагадахдаа 16,470.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар бараа материалыг данс бүртгэлээс хассан зөрчлийг таслан зогсоох.

3. Авлагатай холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 141,151.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох.

4. Өр төлбөртэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны эцэст 16,000,741.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй, үүнээс 155,802.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох.

5. Зардалтай холбоотой

Илрүүлэлт: Ойн газраас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны алба хаагчид болон гэрээт ажилчдад томилолтын зардалд 37,270.0 мянган төгрөгийг, томилолтын тушаалгүй 1,360.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр журам"-ын 2.6-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны

шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтыг тушаал шийдвэргүй олгох, бусад байгууллагын алба хаагчдад томилолтын зардал олгосон зөрчлийг таслан зогсоох.

6. Зардалтай холбоотой

Илрүүлэлт: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны Б/01, А/251, Ойн газрын даргын 2025 оны А/285, А/75 тушаалуудаар гадаад томилолтоор ажилласан алба хаагчдын томилолтын 12,962.1 мянган төгрөгийн зардлын баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.4.4-т "Албан томилолтод шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хэмжээгээр байгууллагын санхүүгээс урьдчилгаа байдлаар олгох бөгөөд зардлын тооцоог томилолтын хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор хийж дуусгана." гэжгэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад томилолтын зардлын баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчлийг таслан зогсоох.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/890 тушаалаар Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хөрсний судалгаа хийх, ногоон бүсэд ойн зурвас байгуулах ажилд 18,681,966.80 мянган төгрөгийн төсөв баталсан боловч хашаа, хамгаалалт байгуулахад 7,121,400.0 мянган төгрөг, усалгааны систем худаг байгуулахад 4,998,698.9 мянган төгрөг, төрийн далбаа мандуулах төмөр шон тээвэрлэн суурилуулах ажилд 10,000.0 мянган төгрөг, нийт 12,130,098.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д " батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1-т "орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт;" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаалаар баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг санхүүжүүлэхгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Ойн газрын даргын 2025 оны А/136 тушаалаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсаас санхүүжилт татах зорилгоор төсөл бичиж боловсруулах ажлын төлбөрийг 15,000.0 мянган төгрөгөөр баталж, ажлын гэрээг 16,725.0 мянган төгрөгөөр буюу 1,725.0 мянган төгрөгийн илүү дүнгээр байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээг байгуулж байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Татварын И-баримт цахим системд 9,001.9 мянган төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.

Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын И-баримт цахим системд төлбөрийн баримтыг бүрэн бүртгэж хэвших.

4. Татвартай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд 21 иргэнд олгосон 6,877.6 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрөөс 687.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож тайлагнаагүй байна.

Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэнд олгох ажил үйлчилгээний төлбөрөөс ХХОАТ-ыг суутган тооцож, тайлагнаж байх.

5. Цалин хөлстэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд Ойжуулалт хөтөлбөрийн зардлаас газрын даргын тушаалаар хөлсөөр ажиллуулах гэрээг 21 иргэнтэй байгуулж, цалингийн зардалд 259,230.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 27,943.4 мянган төгрөг, нийт 287,174.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 272 дугаар тогтоолын 2-т "Ойн газрын

орон тооны дээд хязгаарыг 38 байхаар тогтоосугай”, Ойн газрын даргын 2022 оны А/45 тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.19-д "Батлагдсан төсөвт багтааж албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгө худаадан авч болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тооноос хэтрүүлэн гэрээт ажилтан ажиллуулахгүй байх, ажиллагсдын ажил үүргийг хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг оновчтой зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдан авсан орлогыг 270,502.5 мянган төгрөгөөр илүү, акталсан хөрөнгийн дүнг 5,329.0 мянган төгрөгөөр дутуу, хөрөнгийн ашиглалтын хугацаа, шинэчлэн тогтоосон үнийн дүнг 173.0 мянган төгрөгөөр дутуу тус тус тайлагнасан байна.	1	276,004.5	-	-	-	-	1	276,004.5	-	-	-	-
	Дүн	1	276,004.5	-	-	-	-	1	276,004.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд тус газрын батлагдсан орон тооноос хэтрүүлэн модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хөлсөөр ажиллуулах гэрээг 21 иргэнтэй байгуулж цалинд 259,230.8 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 27,943.4 мянган төгрөгийг тус тус ойжуулалт хөтөлбөрийн зардлаас зарцуулсан байна.	1	287,174.3	-	-	-	-	1	287,174.3
БОУАӨСайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/890 тушаалаар Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хөрсний судалгаа хийх, ногоон бүсэд ойн зурвас байгуулах 18,681,966.8 мянган төгрөгийн төсөв батласан боловч Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хашаа, хамгаалалт байгуулахад 7,121,400.0 мянган төгрөгийг, усалгааны систем худаг байгуулахад 4,998,698.9 мянган төгрөгийг, төрийн далбаа мандуулах төмөр шон тээвэрлэн суурилуулах ажилд 10,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	12,130,098.9	-	-	-	-	1	12,130,098.9
Хандиваар хүлээн авсан бараа материалын дансанд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинж чанартай 39 ширхэг 52,890.0 мянган төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүй шууд зарлагдсан байна.	1	52,890.0	-	-	1	52,890.0	-	-
Ойн газрын даргын А/232 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн 17947 ширхэг 144,599.6 төгрөгийн үнэ бүхий бараа материалыг зарлагдахдаа 16,470.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагдсан байна.	1	16,470.0	-	-	1	16,470.0	-	-
Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 141,151.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	141,151.6	-	-	1	141,151.6	-	-

Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант оны эцэст 16,000,741.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй, үүнээс 155,802.3 мянган төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.	1	155,802.3	-	-	1	155,802.3	-	-
Томилолтоор ажилласан 62 албан хаагчдад хоол унааны хөнгөлөлтийн 1,776.0 мянган төгрөгийг илүү, 999.0 мянган төгрөгийг дутуу тус тус тооцож олгосон байна.	1	1,776.0	1	1,776.0	-	-	-	-
Ойн газраас БОУАӨЯ-ны алба хаагчид болон гэрээт ажилчдад томилолтын зардалд 37,270.0 мянган төгрөгийг, томилолтын тушаалгүй 1,360.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	38,630.0	-	-	1	38,630.0	-	-
БОУАӨС-ын Б/01, А/251, Ойн газрын даргын А/285, А/75 тушаалуудаар гадаад томилолтоор ажилласан алба хаагчдын томилолтын 12,962.1 мянган төгрөгийн зардлын баримтын бүрдэл дутуу байна.	1	12,962.1	-	-	1	12,962.1	-	-
Татварын И-баримт цахим системд 9,001.9 мянган төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.	1	9,001.9	-	-	-	-	1	9,001.9
Ойн газрын даргын А/136 тушаалаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсаас санхүүжилт татах зорилгоор төсөл бичиж боловсруулах ажлын төлбөрийг 15,000.0 мянган төгрөгөөр баталж, ажлын гэрээг 16,725.0 мянган төгрөгөөр буюу 1,725.0 мянган төгрөгийн илүү дүнгээр байгуулсан байна.	1	1,725.0	-	-	-	-	1	1,725.0
Тайлант онд 21 иргэнд олгосон 6,877.6 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрөөс 687.8 мянган төгрөгийн ХХОАТатварыг суутган тооцож тайлагнаагүй байна.	1	687.8	-	-	-	-	1	687.8
Дүн	12	12,848,369.8	1	1,776.0	6	417,906.0	5	12,428,687.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг оруулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ойн газрын даргын Б/08 тушаалаар төрийн жинхэнэ албанаас түр чөлөөлөгдсөн алба хаагчийн суралцах хугацаан дахь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 576.8 мянган төгрөгийг төлсөн нь Засгийн газрын хүчингүй болсон 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх" журмыг үндэслэсэн байна.	1	576.8	-	-	-	-	1	576.8
Ойн газрын даргын А/83, А/92 тушаалаар жүжиг, дуу бүтээх контентын санхүүжилтэнд 31,840.0 мянган төгрөгийг, мөн тушаал шийдвэргүйгээр цай кофены зардалд 6,054.8 мянган төгрөгийг зарцуулж төсвийг үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	37,894.8	-	-	1	37,894.8	-	-
Дүн	2	38,471.6	-	-	1	37,894.8	1	576.8
Нийт дүн	3	38,471.6	-	-	2	37,894.8	1	576.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 21/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/173/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтоор ажилласан 62 алба хаагчдад хоол унааны хөнгөлөлтийн 1,776,000.00 /нэг сая долоон зуун далан зургаан мянган/ төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон хоол унааны хөнгөлөлтийн 1,776,000.00 /хоёр сая долоон зуун далан таван мянган/ төгрөгийг Ойн газрын Хүний нөөцийн мэргэжилтэн Э.Болормаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням, газрын дарга Б.Оюунсанаа нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ойн газрын дарга /Б.Оюунсанаа/, ерөнхий нягтлан бодогч /Г.Ганням/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭР БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0125 SAG-14.Docx

1526200067



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 144/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/173/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хандиваар хүлээн авсан бараа материалын дансанд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинж чанартай 39 ширхэг 52,890,000.00 /тавин хоёр сая найман зуун ерэн мянган/ төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүй шууд зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тушаал шийдвэргүй хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлээс хассан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮВЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 147/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/173/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн газрын даргын 2025 оны А/232 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн 17947 ширхэг 144,599,600.00 /нэг зуун дөчин дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга зургаан зуун/ төгрөгийн үнэ бүхий бараа материалыг зарлагадахдаа 16,470,000.00 /арван зургаан сая дөрвөн зуун далан мянган/ төгрөгийн бараа материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар хөрөнгө, бараа материал данс бүртгэлээс хассан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-20 Docx

1526190381



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 146/A0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/173/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 141,151,579.46 /нэг зуун дөчин нэгэн сая нэг зуун тавин нэгэн мянга таван зуун далан есөн төгрөг дөчин зургаан мөнгө/-ийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 145/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/173/НА - СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 16,000,741,600.00 /арван зургаан тэрбум долоон зуун дөчин нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй, үүнээс 155,802,216.12 /нэг зуун тавин таван сая найман зуун хоёр мянга хоёр зуун арван зургаан төгрөг арван хоёр мөнгө/-ийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийн тооцоог хийж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 142/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/173/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн газраас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны алба хаагчид болон гэрээт ажилчдад томилолтын зардалд 37,270,000.00 /гучин долоон сая хоёр зуун далан мянган/ төгрөг, томилолтын тушаалгүй 1,360,000.00 /нэг сая гурван зуун жаран мянган/ төгрөг нийт 38,630,000.00 /гучин найман сая зургаан зуун гучин мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр журам"-ын 2.6-д "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Томилолтын тушаал шийдвэргүй, тайлангүй, бусад байгууллагын алба хаагчдад томилолтын зардал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 141/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/173/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны Б/01, А/251 дүгээр тушаал, Ойн газрын даргын 2025 оны А/285, А/75 дугаар тушаалуудаар гадаад томилолтоор ажилласан алба хаагчдын томилолтын 12,962,070.00 /арван хоёр сая есөн зуун жаран хоёр мянга далан/ төгрөгийн зардлын баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.4.4-т "Албан томилолтод шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хэмжээгээр байгууллагын санхүүгээс урьдчилгаа байдлаар олгох бөгөөд зардлын тооцоог томилолтын хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор хийж дуусгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Гадаад томилолтын зардлын баримт дутуу бүрдүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-20 Docx

1526180389



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 140/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/173/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд байршуулах мэдээллээс 3 төрлийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор"; 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.6-т "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 142/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/173/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн газрын даргын 2025 оны А/83, А/92 дугаар тушаалаар жүжиг, дуу бүтээх контентын санхүүжилтэд 31,840,000.00 /гучин нэгэн сая найман зуун дөчин мянган/ төгрөгийг олгосон, мөн тушаал шийдвэргүйгээр цай кофены зардалд 6,054,800.00 /зургаан сая тавин дөрвөн мянга найман зуу/ төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1-н "... "Ахмадын өдөр"-өөр хүлээн авч хэлтсийн даргын мэндчилгээ, нэг хүнд 50,000-100.000 хүртэл төгрөгийн бэлэг олгож болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-20.Docx

1526180905